



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2018.01.08 № 05/87
танай _____-ны № _____-т


“МТЗ”ТӨХК, “ГТХЗНТ”УТҮГ, “МИАТ”ТӨХК
“АТҮТ”ТӨҮГ, “ЗТХТ”ТӨҮГ, ДАЛАЙН
ЗАХИРГААНЫ ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 05 дугаар тушаалыг хавсралтаар хүргүүлж байна.


Сайдын тушаалаар өгөгдсөн үүргийн биелэлтийг бүрэн хангаж, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МАХБАЛ



080128

Боловсруусан: Д.Цэцэгмаа
Нийлсэн 
8% Б.Ч
2018.01.08

821080



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/8723 тоот албан бичгээр ирүүлсэн Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа агентлаг, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай:

1.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах;

1.2 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсны дараа албан тушаалд томилох;

1.3 Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргаж хэвшүүлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, худал мэдүүлсэн албан хаагчид хариуцлага хүлээлгэх;

1.4 Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх зэрэг ажилд оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж байх;

1.5 Төрийн жинхэнэ албан тушаалд шинээр томилох асуудлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу шийдвэрлэж, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгож ажиллах;

1.6 Нийтийн албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх, түүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох;

2. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэхтэй холбоотой асуудлаар дараах арга хэмжээг авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай:

2.1 Засгийн газрын 2016 оны "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 3 дугаар тогтоолд тусгагдаагүй бүтцийн нэгжийн асуудлыг шийдвэрлэх;

2.2 Төрийн захиргааны албан тушаалд гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтнуудыг төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтад оруулах, тэнцээгүй тохиолдолд ажлаас чөлөөлөх арга хэмжээ авах;

2.3 Албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлт, үр дүнг бодитой, шударга үнэлж дүгнэж байх, гэрээний биелэлтийг бодитой үнэлж дүгнээгүй нэгжийн дарга нарт хариуцлага тооцох;

3. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга /Л.Бямбасүрэн/-д үүрэг болгох нь:

3.1 Нийтийн албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх, түүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахгүй байхад онцгой анхаарч, ажилтныг ажлаас чөлөөлөх, шинээр томилох асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллах;

3.2 ИНЕГ-ын удирдах албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож буй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

3.3 Иргэний нисэхийн чиглэлийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааг жил бүр хийж, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэж байх;

3.4 ИНЕГ-ын тэтгэлгээр гадаад улсын их дээд сургуулиудад оюутан суралцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлан хэрэгжүүлэх;

3.5 Худалдан авах ажиллагааг хууль, журам зөрчин зохион байгуулсан, шийдвэрлэсэн албан тушаалтанд хариуцлага тооцож, цаашид худалдан авах ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллах;

3.6 Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, уг ажлыг хариуцсан бүтцийг бий болгох.

4. "Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын статус, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцсэн санал боловсруулж танилцуулахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т, "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компанийн гэрээний үүргийн биелэлт, орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, дүнг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т даалгасугай.

САЙД  Ж.БАТ-ЭРДЭНЭ